

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нарийнтээл сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨВА-2024/11/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Арвайхээр хот 2023 он	Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: О.Батжаргал Утас: 70323253 Цахим хаяг: BatjargalO@audit.gov.mn Аудитын менежер: Д.Гансүх Утас: 70323833 Цахим хаяг: GansukhD@audit.gov.com Ахлах аудитор: Б.Эрдэнэцэцэг Утас: 70323108 Цахим хаяг: Erdenetsetsegb@audit.gov.mn Аудитор: Э.Энхбаяр Утас: 70323833 Цахим хаяг: Enkhbayare@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,  
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173.  
Утас/Факс: (976) 7032 3253  
Цахим шуудан: oorkhangra@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

Аудит Ц.Б. 2023 № 143

Тайлан - ны № \_\_\_\_\_ - ү

НАРИЙНТЭЭЛ СУМЫН ТӨСВИЙН  
ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ СУМЫН  
ЗАСАГ ДАРГА Б.СУГАР ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Нарийнтээл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Нарийнтээл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын өс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Нарийнтээл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлүүдийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшнээс давсан нь "Хязгаарлалттай" дүгнэлт өгөх үндэслэл болсон. Тухайлбал:

- Эрсдэлээс хамгаалах сангийн хөрөнгөөр 8.8 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан
- Эрсдэлээс хамгаалах сангийн хөрөнгөөр худалдан авсан 21.6 сая төгрөгийн бараа материалыг нягтлан бодох бүртгэлд бүртгэж, тайлагнаагүй.
- Малын тоо, толгойн албан татварын орлого 63.5 хувь буюу 96.9 сая төгрөг тасарснаас ОНХС-гийн 6 төсөл арга хэмжээг огт хэрэгжээгүй байна

### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд сумын хэмжээнд ОНХС-гийн хөрөнгөөр 256.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, Эрсдэлээс хамгаалах сангийн хөрөнгөөр 3.5 сая төгрөгийн хөрөнгө, сумын ойн хандиваар 4.1 сая төгрөгийн хөрөнгө, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1,025.2 сая төгрөг, Японы Засгийн газрын Өвсний Үндэс буцалтгүй

015009717

тусламжаар 650.0 сая төгрөг, нийт 2,003.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

#### **Аудитын гол асуудал**

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

#### **Бусад асуудлын хэсэг**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31.
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	707,503.3	780,365.6
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,564,433.5	1,609,704.6
	<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>3,271,936.9</b>	<b>3,674,494.3</b>
	Нийт өр төлбөрийн дүн	137,825.9	71,231.9
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,134,110.9	3,603,262.5
	<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>3,271,936.9</b>	<b>3,674,494.3</b>
<b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>			
	Үйл ажиллагааны орлогын дүн	3,668,393.3	3,619,055.6
	Үйл ажиллагааны зардлын дүн	2,739,060.8	2,863,346.4
	<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>929,332.5</b>	<b>755,709.2</b>
	Үйл ажиллагааны бус үр дүн	6,391,096.1	390,059.1
	<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>(5,457,950.3)</b>	<b>365,650.1</b>
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	484,719.5	484,719.5
	Тайлант оны үр дүн	(5,457,950.3)	365,650.1
	<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>3,134,110.9</b>	<b>3,603,262.4</b>
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	2,946,589.9	3,017,845.9
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	2,565,502.4	2,593,432.8
	<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>	<b>381,087.5</b>	<b>424,413.1</b>
	<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>	<b>(349,769.1)</b>	<b>(369,219.2)</b>
	<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>	<b>(765.2)</b>	<b>(149,200.0)</b>
	<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>30,553.3</b>	<b>(94,006.1)</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	409,938.6	440,491.9
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	440,491.9	346,485.8
<b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>			
	<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	1,469,591.2	1,755,953.7
	Урсгал зардал	1,133,071.9	1,256,158.9
	Хөрөнгийн зардал	335,754.1	350,594.7
	<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	1,585,872.6	1,670,895.2
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,108,445.8	1,217,152.6
	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	198,500.4	305,562.5
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	143,185.5	132,905.1
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,590.5	15,275.0
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	118,150.3	-

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 3 зөрчил<sup>1</sup> илэрч, 3 албан шаардлага хүргүүлсэн.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар алдаа зөрчил илрээгүй

### 5.2 Албан шаардлага

1. Тайлант онд малын тоо, толгойн албан татвар 63.5 хувь буюу 96.9 сая төгрөгийг дутуу төвлөрүүлснээс ОНХС-гийн 3 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т “жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх”, 41 дүгээр зүйлийн 41.1-д “Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ.”, 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон .... орлогыг бүрэн төвлөрүүлэх”, 41.2.7-д “хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

#### Шийдвэрлэсэн нь:

Малын тоо, толгойн албан татварын орлогыг бүрэн төвлөрүүлээгүй зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Эрсдэлээс хамгаалах сангийн хөрөнгөөр 15.0 сая төгрөгийн 1000 боодол өвс, 6.6 сая төгрөгийн хивэг худалдан авсныг нягтлан бодох бүртгэлд бүртгэж, тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-д “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.1 “аж ахуйн бүх ажил, гүйлгээ;”, 14.4.6-д “бүх зардал;”- гэсэн заалттай нийцэхгүй байна.

#### Шийдвэрлэсэн нь:

Эрсдэлээс хамгаалах сангийн хөрөнгөөр худалдан авсан бараа, материалыг нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнаагүй зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3. Эрсдэлээс хамгаалах сангийн хөрөнгөөр цагдаагийн албан хаагчийн интернэтийн төлбөрт 0.5 сая төгрөг, сумын Засаг даргын А/190 тоот захирамжаар эмнэлгийн мэргэжилтнүүдэд нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэгт 6.0 сая төгрөг, ахмадын хорооны даргын урамшуулалд 0.8 сая төгрөг, сумын онцгой комисс болон цагдаагийн албан хаагч нарын хоолны зардалд 1.5 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.2-д “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;”, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д “Тусгай сангийн хөрөнгийг батлагдсан төсвөөс хэтрүүлэх, хуульд зааснаас өөр зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно.” гэсэн заалттай нийцэхгүй байна.

#### Шийдвэрлэсэн нь:

Эрсдэлээс хамгаалах сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### 5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### ТТЗ-ийн харьяа байгууллагуудад илэрсэн зөрчлийн талаар

Санхүүгийн тайлангийн аудитаар 2 байгууллага, 3 сангийн тайланг түүвэрт хамруулсан. / ЗДТГ, ИТХ, Эрсдэлээс хамгаалах сан, Хоршоо хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан/

Харьяа байгууллагуудын зөрчлийн нэгтгэлээр 120.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч 3 алдааг залруулж, 3 албан шаардлага хүргүүлсэн байна.

*Нарийнтээл сумын иргэдийн Төлөөлөгчийн Хурал:*

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас авсан 4545.0 мянган төгрөгийн 3 тоног төхөөрөмжийг бүртгэлд тусгаагүй. /алдааг залруулсан/
- Урсгал засварын 1,700.0 мянган төгрөгийн зардлыг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардалд бичсэн. /алдааг залруулсан/
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас 8858.5 мянган төгрөгийг хууль тогтоомжийн дагуу зарцуулаагүй зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.
- Бараа үйлчилгээний бусад зардлаас 952.6 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн зардлаас 290.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх арга хэмжээний зардлаас 599.5 мянган төгрөг, нийт 1842.1 мянган төгрөгийг чиг үүргийн дагуу зарцуулаагүй зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

*Нарийнтээл сумын орон нутгийн хөгжлийн сан:*

- Өмнөх онд 103.5 сая төгрөгийн өр төлбөрийг буруу бүртгэсэн /алдааг залруулсан/
- Шилэн дансанд хөрөнгө мөнгө зарцуулахтай холбоотой гарсан 477,026.5 мянган төгрөгийн 20 тушаал шийдвэрийг байршуулаагүй, 115,000.0 мянган төгрөгийн 2 тендерийн мэдээллийг оруулаагүй, 5 сая төгрөгөөс дээш орлого зарлагын 508,892.0 мянган төгрөгийн 29 гүйлгээг дутуу мэдээлсэн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Дүн	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил	Үүнээс

			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ТТЗ	3	30.4	0	0	3	30.4	0	0	0	0	0	0
Дүн	3	30.4	0	0	3	30.4	0	0	0	0	0	0

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

**/сая төгрөгөөр/**

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
	0	0	0	0	0	0	0	0
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
	0	0	0	0	0	0	0	0
Дүн	0	0	0	0	0	0	0	0
Нийт дүн	3	30.4	0	0	3	30.4	0	0

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

